

## В.ИНЖАННАШИЙН “ХӨХ СУДАР”-ЫН УДИРТГАЛ ТОВЧИТ ТОЛТ ДАХЬ ФИЛОСОФИЙН ЗАРИМ АСУУДАЛ

М.Саранцэцэг - МУБИС, ТНУС-ийн Философи-дидактикийн тэнхим

**Түлхүүр үг:** Таван махбод, хоосон чанар, ертөнцийн ёс, бие хүний төлөвшил, ёс зүй

Их сэтгэгч В.Инжаннашийн “Товчit толт” хэмээх удиртгал нь нийт 12 анги бүхий байсан бөгөөд үүнээс 8 анги нь бидэнд олдоод байгаа юм. 1944 онд Чуулалт хаалганы “Тэргүүн ноёны дармалын газар”-аас Хөх судрын 18 бүлгийг анх хорголжин бараар хэвлэхэд Товчit толтийн 8 анги бүрэн орсон ба бүлэг бүрийн ард цохолбортой байсан байна. Тэр үеэс хойш Товчit толт, Хөх сударын эхэнд тусгайлан хэвлэгдсээр иржээ. Энэхүү өгүүллийг бичихдээ 2005 онд Улаанбаатар хотод хэвлэгдсэн В.Инжаннашийн “Хөх судар” дахь Товчit толтийг сурвалж болгон ашиглав. “Монгол тоотон бүгдээр уг үндэс ба язгуур удмаа мэдтүгэй” хэмээн бие хэл сэтгэлийг гүнээ чилээн байж туурвисан Товчit толт хэмээх эл бүтээл бол их сэтгэгчийн философи үзлийн хураангуй илэрхийлэл мөн гэж хэлж болно.

В.Инжаннаши энэхүү бүтээлдээ юуны өмнө арга билиг хоёр амьсгалын тухай, өөрөөр хэлбэл хий буюу уурын тухай авч үзжээ. Тэрээр бичихдээ “Энэ орчлон хэмээгч тэнгэр, газар, нар, сарнаас дараалан түмэн бодис хүргэл цөмөөр арга, билгийн хоёр амьсгалаас үүсгэж, таван махбодийн зүй, шалтгаан лугаа хослолдон барилдаж бүтээд, дэлхий дүүрэн бодис юмс дэлгэрсний тулд, дэлхий дахины түмэн бодист зүй үгүйн бээр үгүй, гагц зүйгий нь мохоож бодохуйд буй хэмээсэн болой” /1/ гэжээ. Эндээс үзвэл хослолдон оршихуйн дотор аргын амьсгал, билгийн амьсгал хоёр хоршин нэгдэж, зүй шалтгаанаараа хувирч, өөрчлөгдөж, ертөнцийн бүхий л юмыг бүрэлдүүлсэн байна.

Түүний бичсэнээр бүх юм тогтоноходо төмөр, ус, гал, шороо хэмээх таван махбодоос бүтдэг. Тэгэхдээ модноос гал, галнаас шороо, шорооноос төмөр, төмрөөс ус, уснаас мод тус тус гарах ажээ. Түүнчлэн шороон махбод бол алив бодисын суурь түшиг, усан махбод бол бодисын эх сурвалж, үүсэх шалтгаан, гал махбод бол илчийн эх. Илчийн үйлдлээр алив бодис боловсорно. Хий махбод хөдөлгөөн үүсгэж арвижуулна. Огторгуй махбод арвижин өсөхийн суурь болдог хэмээн үзжээ. Ийнхүү бүх юмс үзэгдэл харилцан жам ёс, зайлшгүй холбоо, шалтгаацлалтай байдаг болой.

В.Инжаннаши ертөнцийн зүй тогтол, жам хуулийн асуудлыг ихэд чухалчлан үзжээ. “Ертөнц, түмэн бодис зүй үгүйгээр нэгээхэн ч үгүй”, “Үүсэх ба устах”, “барагдашгүйгээр дордоос дээшид хөгжин орох үргэлжилсэн явцаас өөр юу ч үгүй”, “бүгдэд өөр өөрийн цаг, тоо хэмжээ, улирал буй” /2/ ажээ.

Энэхүү ертөнцийн жам ёс, цагийн эрхийг хэн ч сөрөн зогсож чадахгүй гэдгийг В.Инжаннаши олон талаас нь нягтлан маш тодорхой илэрхийлж:

«...аль дөрвөн цагийн амьсгал хэмээвээс, хаврын хүмүүжих цагийг хариулахуйяа бэрх, зуны тунарсан үеийг сэргээхүйеэ бэрх, намрын жихүүрсэн хэмжээг дулаалахуйяа бэрх, өвлийн хөлдсөн есийг гэсгээхүйеэ бэрх, цөм өөр өөрийн цаг тоо хэмжээ улирал болой. Тэнгэр, боловч хэрхээн чадах? Ҳаврын өглөөний нэгэн цагийн жиχүүн, борооңирор, зуун . . . . . бодисыг хэрхэн хөлдөөн чадах? Зуны нэгэн шөний хойно, салхиар түмэн үрсийг хэрхэн боловсруулан чадах? Намрын нэгэн үдийн найрамдуу уураар түмэн цэцгийг хэрхэн дэлгэрүүлэн чадах? Өвлийн нэгэн өдрийн дулаанаар түмэн ичигсэдийг хэрхэн хөдөлгөн чадах?” /3/ гэж хэлсэн байдал.

Тэрбээр цааш нь “Нэгэн нар, нэгэн сар, хоёр гэрэл хоёр сүүдэртэй, зургаан дурс

буюу Нар аваас гэрэл амуй, гэрэл аваас сүүдэр амуй, саран аваас туяа амуй, туяа аваас бас сүүдэр амуй. тагц нарны гэрэл нь маш хурцын тул сүүдэр мөн тодорхой, сарны туяа эгнэгт бүдэг тул сүүдэр мөн балархай. ...Жич саран хэмээгч нарны гэрэлд сая гилтэгнэж, туяа цацрах тул эгнэгт басхүү нарны шалтгаан мэт, ...Гагцхүү нарны явахыг тогтоон хэмжиж, цаг мөч сүүдэр хэмжээтэй болсноор, хэдийгээр бодисын сүүдрээр боловч цагийг мэдэж болмуй” /4/ гэж бичжээ.

В.Инжаннаши энд 3 зүйл, тухайлбал 1-рт ертөнцийн юмс үзэгдэл цөм харилцан бие биеэ нөхцөлдүүлсэн шалтгаант холбоонд холбогдсон байдгийг, 2-рт алив юмс үзэгдлийн шинж чанар уг бодит юмтайгаа шууд холбоотойг, 3-рт юмсын шинж чанар бол уг бодит юмтайгаа нэгэн адил объектив бодит шинжтэйг онцлон тэмдэглэжээ.

В.Инжаннаши төв ёсны үзлийг хоосон чанарын онолыг тайлбарлахдаа: “...номд хоосныг мохол болгож орчлонгийн мэргэдийг хоосны хойноос хөөлгөжүүхүй. Бичигт буйг баримтлаж, ергөнцийн амьтныг буйн хойноос нэхүүлжүүхүй.” /5/

«...Үнэнийг хэлбээс, энэ буй хоосон хэмээх үгсийг хэлэхүйд, хоёр өөр үгс боловч санаа нь нэг болой. Учир юун хэмээвээс буйн учир сая хоосон хэмээсэн нэгэн үгс гарсан болой. Хоосон хэмээсэн нэгэн үгс байх тул, бас сая буй хэмээх нэгэн үг зохиожуухүй. Энэ буй хоосон хоёул толгой сүүл залгагдсан нэгэн гархи мэт үг буюу. Битүү илэрхийгээр үлитгэвээс хүн амьтан амьт цагт буй, үхэж эчвээс хоосон, бод юм бүтэж байваас буй, эвдэрч барагдваас хоосон. Бас үлитгэвээс эртний өнгөрсөн тэдгээр түмэн, мянган зүйлийн улс төрийн хүн амьтан аху цагтаа цөм буй бүлгээ, эдүгээ өнгөрөөд цөм хоосон болжуухуй. Эдүгээ маны энэ улс, энэ биес эдүгээ үзтэл цөм буй бөгөөтөл, эцэст бас хоосон болохоос хэрхэвч хэлтрэн чадахгүй тул буй бөгөөд хоосон бус юун?. Бид хоосон болж эчсэн хойно, тэр үеийн хойчийн хүн бас буй тул хоосон бөгөөд буй бус юун? Тийнхүү буй хэмээвээс цөм буй, хоосон хэмээвээс цөм хоосон, буйн хойноос хоосон даруй дагаж явмуй, хоосны дотроос буй бүтэж гармуй. Тийнхүү буй ч мөн хоосон, хоосон ч мөн буй. Энэ буй хоосон хоёул харилцан маш янаг, маш амраг шууд нэгэн үгс болохгүй хайш эчмүй?” /6/ гэжээ. Үүний хамт В.Инжаннаши олон урсгал үзлийн байр сууринд буйгаа илэрхийлж “...мухагаа аль ч сургаалд эс нэвтэрсэн боловч аль сургаалыг дотроо тасархай буруу хэмээн санахгүй” /7/ гэжээ.

В.Инжаннаши монгол орон харийн түрэмгийлэлд автаж, дэлхийн хөгжлөөс гээгдэж, олон зууны хоцрогдолд орсныг илчлэн хурц шүүмжлэж байлаа. Ялангуяа бурханы шашин ихэд дэлгэрсэн нь аж ахуйд ажиллах, батлан хамгаалах цэргийн хүч цөөрч татархуйн их аюулд оруулж буй хэмээн санаа зовниж байжээ. Тэрбээр бичихдээ хүүхэд залуусыг нэн олноор нь лам болгож зөвхөн төвд ном уншуулж, үндэсний бичи ном сурахыг хязгаарлах нь муухаг явдал. Монголчууд төвд номоор онол ухааныг ухана хэмээгч өдрийн од, шөнийн солонго мэт цөөн хэмээн монгол бичиг номоо үзэхийн шоовдорлох хуурамч гарз /хүдрийн заар/ дэлгэрч буй нь хор уршигтай болохыг онцлон зааж байлаа.

Мөн Хятад хүүхэд үржих нь хялбар, хурдан. Манай Монголын адил бурхан болно хэмээн олноор хувраг болгон үрийг таслан бүрэлгэн saatuuлах зүйлгүй. Монголчууд шашин суртлыг нэвт сүслэн дагаж, номхон хүлцэнгүйд хэт автаж, олон олноор лам болохыг хөөцөлдөх нь хүн амын өсөлт цөөрөх, төр цэргийн албыг цалгардуулах, нэн из энхжих хор хөнөөлтэйг удаа дараа анхааруулж байв.

В.Инжаннаши “...Арга билгийн хоёр амьсгал бүхүй газарт хүн амьтныг төрж үүсгэмүй. Нэгэнт хүн төрөлхтний биеийг авч төрвөөс эрхбиш мэдэл оюун амуй” /8/ хэмээгээд улс орон бүрийн мандах, буурахын учрыг ертөнц наран, саран, байгаль, дэлхий

ур амьсгалтай холбооос гадна тухайн улс үндэсний төрийн хүч чадал, баримтлах бодлого, онол номлол ихээхэн учир холбогдолтойг товайлгон үзэж байлаа.

“Би хэдийбээр ном, бичгийг хамтаар хэрэглэвч эгнэгт ертөнцийн ёсноос үл хэтрүүлмүй. Энэ нь улс тогтносны хойно хэрэглэх үйл, хэрвээ улс байгуулсан тулгар нээхийн үеийн хэрэг болбоос ганц ертөнцийн эрхээс бус болбоос үл болмуй” /9/ гэсэн байдаг. В.Инжаннаши “ном” ба “бичиг” сургаалаас гадна “ертөнцийн ёс” хэмээхийг дээдлэн тавьсан. Энэ нь түүний сэтгэлгээний нэг онцлог юм.

В.Инжаннаши бол Манж Чин улсын ноёрхолын эсрэг монгол үндэстнийхээ тусгаар тогтнолын төлөө тууштай тэмцэгч байлаа. Монголчууд чийрэгжвэл улсын зовлон, монголчууд доройтвол улсын буян гэж манж Чин улсын Сайшаалт ерөөлт хааны хэлсэн үг монголын талаархи манжийн төрийн бодлогын үндэс болж тэдний ноёрхолын бүх түүхийн турш хадгалагдаж байлаа. Энэ бодлогыг “аяа юутай учрах хувь заяа юутай хорсолтой хууль ёс” /10/ гэж В.Инжаннаши халаглан бичсэн буй.

Тэрээр Монголын нийгэм дотоод зөрчилдөө идэгдэн доройтож буйг олж харсан юм. “Нэгэн төрлийн баян ядуу хоёрын тэмцэлдээн, нэгэн төрлийн зальхай ба цэгцийн тэмцэлдээн, амьдрал унтралын зам мөр ч өөр өөр ашиг хүслийн эрэлт, уналт ч ас асдаан” /11/ явагдаж эдүгээ цагт харгис түшмэл ховдог ноёд сайд улсаар дүүрэн /12/ боллоо гэжээ.

В.Инжаннаши феодал ноёдын угсаа залгамжлах ёсыг хүрц шүүмжилсэн юм. “Зургаан ужид хэмээгч тэргүүнд архи, дээдэд өнгө, гуравт ан аян, дөрөвдүгээр нь хөг дуу, тавд цэцэрлэг хүрээлэн, зургаад наадам хөөр энэ буюу. Энэ зургаан зүйлийн ужидын нэгэн зүйл нь хүний биед аваас улс хаан бөгөөс улсаа алдмуй, гэрийн эзэд бөгөөс аж төрөхөө алдаж хохирмуй.” /13/ гэсэн байдаг.

Төрийн эзэн ихэс ямар байх вэ? Энэ асуултанд хариулт болгож В.Инжаннаши бичихдээ: “нүд сэтгэл наран мэт гэгээн, бодлого ухаан далай мэт уудам, бие дор чийрэг, баатар буй, сэтгэл дор уудам эрдэм буй, мэргэд бээр хянан сэтгэвээс сая түүний туйлын гайхамшигийг уламжлан төсөөлмүй” хэмээн бие, сэтгэл бодлого ухаанаар нь тухайлж тодорхойлжээ.

Бие хүний хүмүүжил төлөвшлийн тухай В.Инжаннашийн үзэл санаа их сонирхолтой юм. Тэрээр хүн тухайн эрин цагийнхаа бүтээгдэхүүн байдаг гэж үзэж бичихдээ: “Хүн төрөлхтний эхээс төрөх нэгэн хурим, энэ бие бүтэхийн нэгэн хурим, эцэслэн үхэхийн нэгэн хурим, бас эр хүний бие бүтэхийн, бага хүмүүжил, энэ биеийг эрхэм болохыг их хүмүүжил хэмээжүхүй. Бага хүмүүжил хэмээгч тарьж арчлах цаг мэт үндэс хатгахыг эрээд, их хүмүүжил хэмээгч хадах хураах үе адил ачлалыг гүйцэтгэхийг эрхэлжүхүй. Энэ гурван хурим хоёр хүмүүжил хүмүүн боловчдын таван чухал үйлс тул, дөрвөн этгээдийн олон улс эрхбиш бэлээглэн дүрэмлэхийг эрхэлжүхүй. ... хүн сая эхийн хэвэлд тогтон бүтэхүйд таван махбодод бүрдэж, сая бие цогц бүрдэн хүмүүжих”-ийг /14/ үндэслэжээ.

В.Инжаннаши ёс зүй хэмээх нэр томъёог уг бүтээлд хэрэглэхийн “Сайныг цогцолсон гэрт сааргүй сайн бэлгэ үлэмж, мууг цугларуулсан гэрт магадаар муу ёр мэдэгдмүй” /15/ хамт бие хүн, өрх гэр, засаг төрийн ёс суртлыг тод томруун тодорхойлжээ. Энэ талаар “Их суртахуун бичиг”-тээ:

- „Хүний эзэн, бологчид ёршөөлд зогс . . . . .
- Хүний сайд бологчид хичээнгүйд зогс
- Хүний хөвгүүн бологчид ачлалд зогс
- Хүний эцэг бологчид асралд зогс
- Улсын хүн лүгээ нөхөрлөвөөс итгэмжид зогс

Хэмээсэн нэгэн анги бүрнээ багтажухуй

Эцэг хөвгүүний амраг, эзэн сайдын журам, ах дүүгийн элэгсэг, нөхөр эмийн янаг, хань нөхдийн бат эс бүрдсэн нь үгүй.” /16/ гэжээ.

В.Инжаннаши нь ертөнцийн юмс үзэгдлийн хувьсан өөрчлөгдөх шалтгаан нь түүний дотоод дахь мөн чанартай холбоотой болохыг тусгасны зэрэгцээ нийгмийн дотоод дахь зөрчлийг илчлэн шүүмжлэж өөрийн зохиол бүтээлээ тууриваж байжээ.

Иш авсан бүтээлүүд

1. В.Инжаннаши “Хөх судар” тэргүүн дэвтэр УБ 2005 13-р тал.
2. Мөн тэнд, 601-р тал
3. Мөн тэнд, 600-601-р тал
4. Мөн тэнд, 624-р тал
5. Мөн тэнд, 94-р тал
6. Мөн тэнд, 94-95-р тал
7. Мөн тэнд, 53-54-р тал
8. Мөн тэнд, 56-р тал
9. Мөн тэнд, 38-р тал
10. Монголын гүн ухааны түүх УБ 1987 528-р тал
11. В.Инжаннаши “Хөх судар” тэргүүн дэвтэр УБ 2005 37-р тал
12. Мөн тэнд, 90-р тал
13. Мөн тэнд, 173-р тал
14. Мөн тэнд, 166-167-р тал
15. Мөн тэнд, 138-р тал
16. Мөн тэнд, 400-р тал